



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

*Үндэсний аудитын газрын 2014 оны бүтээгдэхүүн
ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийсэн
нийцлийн аудитын тайлан*



**БҮХ НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮҮРГИЙН САНГИЙН
ХӨРӨНГИЙН ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ,
ҮР ДҮН**

**Улаанбаатар хот
2014 он**

Агуулга

Тайланг бэлтгэсэн: ҮАГ-ын Нийцлийн аудитын газар		Товчилсон үгийн жагсаалт	2
<i>НАГ-ын дарга Б.Алтанзул</i>		Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	3
<i>Аудитын менежер З.Ариунзаяа</i>		Ерөнхий мэдээлэл	4
		Бүлэг 1: Сангийн хөрөнгө бүрэн төвлөрөөгүй байна	
<i>Шинжээч</i>	<i>Ш.Наранбаатар</i>	<ul style="list-style-type: none"> БНҮҮС-д төвлөрөх хөрөнгийг хангалтгүй бүрдүүлж байна 	5
		Бүлэг 2: Төсөл хөтөлбөрийн хэрэгжилт үр дүн	
		<ul style="list-style-type: none"> Хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн үр дүнд ашиглалтад орсон өмч хөрөнгө, тоног төхөөрөмжийг нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу анхан шатны бүртгэлд бүртгэж аваагүй байна 	8
		Бүлэг 3: Хяналтын зөвлөлийн үйл ажиллагаа хангалтгүй байна.	
		<ul style="list-style-type: none"> БНҮҮС-ийн үйл ажиллагааны дүрмийг мөрдөж ажиллаагүй байна 	14
		Дүгнэлт	15
		Зөвлөмж	16
		Холбогдох байгууллагын санал	17
		Саналд өгсөн тайлбар	24
2014 оны 4 дүгээр сар		Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаал	25
<p>Уг тайланг ҮАГ-ын Веб сайт-аас үзнэ үү. www.audit.mn Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261729 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу.</p> <p>ХАЯГ: Үндэсний аудитын газар 210642 Чингэлтэй дүүрэг, Засгийн газрын 4 дүгээр байр, Бага тойруу-6, Улаанбаатар-46 Монгол Улс</p>			

Товчилсон үгийн жагсаалт

УИХ	Улсын Их Хурал
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
МШХХТГ	Мэдээлэл шуудан харилцаа холбоо технологийн газар
БНҮҮС	Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан
ХХЗХ	Харилцаа холбооны зохицуулах хороо
ТББ	Төрийн бус байгууллага
ЕхPS	Улс хоорондын буухиа шуудангийн үйлчилгээ
IPS	Улс хоорондын шуудангийн илгээлтийн үйлчилгээ эрхлэх
БНҮҮСХТЖ	Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санд хөрөнгө төвлөрүүлэх журам
БНҮҮСҮАД	Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн үйл ажиллагааны дүрэм
ХХЗХ	Харилцаа холбооны зохицуулах хороо

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Монгол Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2014 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн 3 дугаар тогтоол, ҮАГ-аас МУ-ын Ерөнхий Аудитор 2014 онд нийлүүлэх бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт

БНҮҮС-ийн хөрөнгийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүнг шалган дүгнэлт, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- Сангийн хөрөнгийн орлогын бүрдүүлэлт, хуваарилалт зохих журмын дагуу хийгдэж байгаа эсэх;
- Сангийн хөрөнгийн зарцуулалт, ашиглалт үр нөлөөтэй эсэх

Хамарсан хүрээ

Аудитад МТШХХГ-ын Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн Ажлын алба, тухайн төсөл хөтөлбөр хэрэгжүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагааг хамруулав.

Арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, гүйцэтгэлийн аудитын гарын авлага, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу дараах арга зүйг ашиглав. Үүнд:

- БНҮҮС-ийн орлогын бүрдүүлэлтийг түүвэрлэн шалгасан;
- Холбогдох эрхийн актыг судалсан;
- БНҮҮС-ийн хөрөнгийн төлөвлөлттэй холбоотой судалгаанд дүн шинжилгээ хийсэн;
- БНҮҮС-аас бараа, ажил үйлчилгээг ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу худалдан авсан эсэхийг түүвэрлэн шалгасан;

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ, судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Ерөнхий мэдээлэл

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан нь Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Харилцаа холбооны тухай хууль болон Засгийн газрын 2009 оны 151-р тогтоолоор баталсан “Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан бүрдүүлэх, зарцуулах журам”-д заасны дагуу харилцаа холбооны үйлчилгээ эрхэлж байгаа хуулийн этгээдээс төвлөрүүлсэн хөрөнгөөр төрийн бодлогын хүрээнд зайлшгүй шаардлагатай мэдээлэл, шуудан, харилцаа холбооны үйлчилгээг алслагдсан орон нутаг болон үйлчилгээ хүрээгүй хүн амд хүргэх үүргийг хэрэгжүүлдэг байна.

БНҮҮС-ийн орлого нь мэдээлэл, шуудан харилцаа холбооны тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс тухайн этгээдийн албан татвар ногдох орлогын 2 хувьтай тэнцэх хөрөнгө, шуудангийн үйлчилгээний давуу эрхийн бүсэд үйлчилгээ үзүүлэгч шуудангийн тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс төвлөрүүлэх хөрөнгийн эх үүсвэрээс тус тус бүрдэж байна.

Шуудангийн үйлчилгээний давуу эрхийн бүсэд үйлчилгээ үзүүлэгч аж ахуйн нэгжээс Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг “Харилцаа холбооны зохицуулах хороо”-ны хуралдааны 2010 оны 48 дугаар тогтоолоор 2011 онд санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг Улаанбаатар хотод 1.5 сая төгрөг, Орхон, Дархан-Уул аймгуудад 0.8 сая төгрөгөөр тус тус тогтоосон боловч өнөөдрийг хүртэл энэ хэмжээг мөрдөж байна.

“Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санг бүрдүүлэх, зарцуулах журам”-д заасны дагуу сангийн хөрөнгө төвлөрүүлэх, зарцуулалтыг хянах, өдөр тутмын үйл ажиллагаатай холбогдсон харилцааг МШХХТГ хариуцаж ажилладаг байна.

Сангийн бүтэц, орон тоог МШХХТГ-ын дарга 7 хүний бүрэлдэхүүнтэй байхаар тогтоож Ерөнхий менежер, ажлын албатай байхаар баталсан байна.

Тус сангийн орон тооны бус Хяналтын зөвлөлийг МТШХХГ-ын даргын шийдвэрээр мэдээлэл технологийн салбар дахь төрийн болон хувийн хэвшлийн төлөөллөөс бүрдсэн 9 гишүүний бүрэлдэхүүнтэй 2 жилийн хугацаанд ажиллуулдаг байна.

Уг хяналтын зөвлөл нь БНҮҮС-ийн үйл ажиллагаа холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу явагдаж байгаа эсэх, хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалттай танилцаж санал зөвлөмж өгөх, сангийн тухайн жилд хэрэгжих төсөл хөтөлбөрийн төлөвлөгөөнд санал зөвлөмж гаргах, баталсан арга хэмжээний биелэлт үр дүнг нийтэд мэдээлэхэд оролцох эрх үүрэгтэй ажилладаг байна.

БҮЛЭГ 1. 2013 ОНД САНД ТӨВЛӨРӨХ ХӨРӨНГИЙГ БҮРЭН ТӨВЛӨРҮҮЛЭЭГҮЙ БАЙНА

БНҮҮС-ийн бүрдүүлэхдээ холбогдох арга хэмжээг хэрэгжүүлсэн боловч үр дүн муутай байна.

1.1 “МУ-ын 2013 оны төсвийн тухай” хуульд Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн орлогыг 3.5 тэрбум төгрөг байхаар УИХ баталжээ.

1.2 БНҮҮС-д 2013 онд төвлөрөх 3,6 тэрбум төгрөгөөс татвар ногдох орлогоос төвлөрүүлэх хөрөнгө болох 3,5 тэрбум төгрөгийг нэр бүхий 9 төсөл хөтөлбөр болох үүрэн холбоо, интернэт, шуудан, радио телевиз, судалгаа сурталчилгааны ажилд, өөрийн хөрөнгөөс төвлөрөх 140.0 сая төгрөгийг сангийн дотоод үйл ажиллагаа болон урсгал зардалд зарцуулахаар Монгол Улсын Ерөнхий сайд 2013 оны төсвийн төлөвлөгөөг баталсан байна.

1.3 БНҮҮС-ийн орлогын бүрдүүлэлт, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тоог сүүлийн таван жилийн байдлаар хүснэгтээр үзүүлбэл:

Утга		2009	2010	2011	2012	2013	Нийт дүн/тайлбар
Хөрөнгө төвлөрүүлэлт /тэрбум/	Төлөвлөгөө	2,3	1,9	2,5	3,5	3,5	13.7
	Гүйцэтгэл	1,8	3,3	3,3	4,3	2,9	15.6
ХХЗХ-с Тусгай зөвшөөрөл эзэмшигчдын тоо		629	653	657	656	501	Тайлбар: 88 байгууллага хаяг тодорхойгүй, 156 ААН тодорхой шалтгаангүйгээр тайлан ирүүлээгүй, 89 ААН хасах баланстай тайлан ирүүлсэн.
Мэдээлэл хүргүүлсэн байгууллагын тоо		170	197	307	326	413	
Тайлан ирүүлсэн байгууллагын тоо		120	168	174	145	257	
Хөрөнгө төвлөрүүлсэн байгууллагын тоо		31	66	78	43	71	

2013 онд тус санд нийт 3.6 тэрбум төгрөгийг тусгай зөвшөөрөл эзэмшигч нийт 501 байгууллага төвлөрүүлэхээс 71 байгууллага 2.9 тэрбум төгрөг төвлөрүүлсэн нь санд төвлөрөх нийт хөрөнгийн 80.5 хувь байна.

МШХХТГ-аас 413 аж ахуйн нэгжид мэдээлэл хүргүүлж, санхүүгийн тайлангаа 257 аж ахуйн нэгж ирүүлсэн байна. Эдгээр аж ахуйн нэгжээс 175 нь алдагдалтай ажилласан тайлан тэнцэл ирүүлж, 71 нь хөрөнгө төвлөрүүлж, 2009-2013 оны 97 байгууллагаас 845.0 сая төгрөгийн авлагатай байна.

Санд төвлөрүүлсэн хөрөнгийн төлөвлөгөөний биелэлтийг хүснэгтээр үзүүлбэл:

№	Байгууллагын нэрс	Нийт тоо	Мэдээлэл хүргэсэн	Тайлангаа ирүүлсэн	Хөрөнгө төвлөрүүлэлт
1	Үүрэн суурин холбооны үйлчилгээ эрхэлдэг байгууллагууд	5	5	5	5
2	Телевизийн байгууллагууд	198	147	77	11
3	Интернэтийн үйлчилгээ үзүүлдэг	27	27	19	10
4	Холбооны шугам угсралтын ТЗЭ	218	217	135	21

- Үүрэн болон суурин холбооны “Мобиком” ХХК, “Скайтел” ХХК, “МЦХ” ХК, “Жи-Мобайл” ХХК “Юнител” ХХК зэрэг 5 байгууллага татвар, хураамжаа төлж тайлангаа ирүүлж, “Жи-Мобайл” ХХК 9.8 сая төгрөг, “Юнител” ХХК 398.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй;
- Телевизийн 198 байгууллагаас 77 байгууллага санхүүгийн тайлангаа ирүүлж 11 байгууллага холбогдох татвар хураамжаа төлсөн, 16 аж ахуйн нэгж 79.7 сая төгрөгийн татвар хураамжын үлдэгдэлтэй, үлдэх 50 байгууллага үйл ажиллагаа явуулаагүй тул хөрөнгө төвлөрүүлээгүй байна. Хөрөнгө төвлөрүүлэх тухай албан бичиг явуулсан 147 байгууллагаас 51 байгууллагын хаяг байршил, үйл ажиллагаа явуулж буй эсэх нь тодорхойгүйгээс санд төвлөрөх хөрөнгө дутуу биелэхэд нөлөөлсөн;
- Интернет үйлчилгээний 27 тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжээс 19 нь санхүүгийн тайлангаа ирүүлж нэр бүхий 10 аж ахуйн нэгж татвар хураамжаа төлж, 13 аж ахуйн нэгж 162.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй;
- Холбооны шугам угсралтын 218 тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжээс 135 аж ахуйн нэгж санхүүгийн тайлангаа ирүүлсэн, үүнээс 21 аж ахуйн нэгж татвар хураамжаа бүрэн төлсөн, нэр бүхий 14 байгууллага 12.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Тусгай зөвшөөрөл эзэмшигч 83 аж ахуйн нэгжийн хаяг байршил тодорхой бус, 100 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа явуулж буй эсэх нь тодорхойгүйгээс санд төвлөрөх хөрөнгө дутуу биелэхэд тус тус нөлөөлсөн байна.

МШХХТГ БНҮҮС-д төвлөрөх хөрөнгийг бүрэн бүрдүүлээгүй нь аудитын явцад тогтоогдсон бөгөөд “Засгийн газрын тусгай сангийн тухай” хуулийн 22 дугаар зүйлийн 22.1¹, 22.2² дахь заалт, “БНҮҮС-д хөрөнгө төвлөрүүлэх журам”-ын 3³ дугаар зүйлд заасан үүргийг биелүүлээгүй, тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүд мөн журмын 4⁴ дүгээр зүйлд заасан үүргийг тус тус биелүүлээгүй байна.

1.4. Шуудангийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжээс БНҮҮС-д төвлөрүүлсэн хөрөнгийн байдлыг он тус бүрээр хүснэгтээр үзүүлбэл:

Утга	2009	2010	2011	2012	2013
Хөрөнгө төвлөрүүлэлт /сая.төг/	11,7	6,2	28,2	17,7	59,5
ХХЗХ-ноос тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тоо/шуудангийн үзүүлэлт/	44	56	59	60	64
Хөрөнгө төвлөрүүлсэн байгууллагын тоо	19	10	17	9	21

Дээрх хүснэгтээс үзэхэд 2013 оны санд төвлөрүүлэх хөрөнгө өмнөх 2012 оноос 40 гаруй сая төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлтэй байгаа ч ХХЗХ-ны олгосон 64 тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжээс 21 аж ахуйн нэгж хөрөнгө төвлөрүүлсэн, 43 болон өмнөх оны үлдэгдэлтэй 9 аж ахуйн нэгж 182 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Сангийн удирдлага ХХЗХ-той хамтран шуудангийн салбараас санд төвлөрүүлэх хөрөнгийн тодорхойлолтыг үндэслэн 2013 оноос лиценз сунгах асуудлыг

¹ Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгө нь дор дурдсан эх үүсвэрээс бүрдэнэ: энэ хуулийн 7.2-т заасан эх үүсвэр; харилцаа холбооны үйлчилгээ эрхэлж байгаа хуулийн этгээдээс төвлөрүүлсэн хөрөнгө.

²22.2.Энэ хуулийн 22.1.2-т зааснаар төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ нь тухайн этгээдийн албан татвар ногдуулах орлогын 2 хувьтай тэнцүү байна.

³ Тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс санд хөрөнгө төвлөрүүлэх, тайланг журмын маягтын дагуу гаргуулан, татварын албанд тайлагнасан санхүүгийн тайлангийн хамт тайлант улирлын дараа улирлын эхний сарын 25-ны дотор авах, ирүүлэхийг шаардах.

⁴ МШХХТГ-аас баталсан санд хөрөнгө төвлөрүүлэх тайлангийн маягыг мөрдөх, Тухайн улиралд санд төвлөрүүлэхээр МШХХТГ-аас баталгаажуулсан хөрөнгийг дараа улирлын дундах сарын 25-ны дотор Төв төрийн сангийн дансанд төвлөрүүлэх,

шийдвэрлэдэг болсон нь үр дүнгээ өгч эхэлсэн байна. 2012 онд 60 тусгай зөвшөөрөл эзэмшигчийн дөнгөж 9 нь хөрөнгө төвлөрүүлж байсан бол 2013 онд 12 тусгай зөвшөөрөл эзэмшигч нэмэгдэж хөрөнгө төвлөрүүлсэн байна.

1.5 Дээрхээс үзэхэд тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүд “Шуудангийн тухай хууль”-ийн 17 дугаар зүйлийн 17.2.2⁵ дахь заалт, “БНҮҮС-д хөрөнгө төвлөрүүлэх журам”-ын 4⁶ дүгээр зүйлийг биелүүлээгүй, мөн МШХХТГ “БНҮҮС-д хөрөнгө төвлөрүүлэх журам”-ын 3⁷ дугаар зүйлийг тус тус биелүүлээгүй байна.

1.6 БНҮҮС-д хөрөнгө төвлөрүүлэх журамд заасан татварт ногдох орлогоор сангийн хөрөнгийг бүрдүүлж байгаа боловч тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагууд ашигтай ажилласан бол татвараа төлдөг ашиггүй ажилласан бол хөрөнгө төвлөрүүлдэггүй байдал гарч байгаа тул тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжээс суурь хураамжийг жил бүр авч байх эсвэл орлого бүрдүүлэх механизмыг БНҮҮС-д хөрөнгө төвлөрүүлэх журамд өөрчлөн тусгах шаардлагатай байна.

⁵. шуудангийн үйлчилгээний хураамжийг зохих журмын дагуу төлөх;

⁶ МШХХТГ-аас баталсан санд хөрөнгө төвлөрүүлэх тайлангийн маягыг мөрдөх, Тухайн улиралд санд төвлөрүүлэхээр МШХХТГ-аас баталгаажуулсан хөрөнгийг дараа улирлын дундах сарын 25-ны дотор Төв төрийн сангийн дансанд төвлөрүүлэх,

⁷ Тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс санд хөрөнгө төвлөрүүлэх, тайланг журмын маягтын дагуу гаргуулан, татварын албанд тайлагнасан санхүүгийн тайлангийн хамт тайлант улирлын дараа улирлын эхний сарын 25-ны дотор авах, ирүүлэхийг шаардах.

БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн үр дүнд ашиглалтад орсон өмч хөрөнгө, тоног төхөөрөмжийг нягтлан бодох бүртгэлийн тухай хуулий дагуу анхан шатны бүртгэлд бүртгэж аваагүй байна.

2.1 2013 онд аймаг орон нутгийн иргэдэд үүрэн холбооны болон интернетийн үйлчилгээ хүргэх, шуудангийн үйлчилгээний хүргэлт, давтамжийг нэмэгдүүлэх телевизийн олон суваг хүргэх хамрах хүрээг нэмэгдүүлэх, тоон технологид суурилсан радио өргөн нэвтрүүлгийн ажилд Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгөөс 21 аймгийн давхардсан тоогоор алслагдсан 241 сум, 3 багт нийт 2,7 тэрбум төгрөгийн санхүүжилт хийж доорх хүснэгтэд дурьдсан арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

№	2013 онд хийхээр төлөвлөсөн ажил үйлчилгээ	(сая төг)	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Хөдөө орон нутгийн алслагдсан сум, суурин газарт утасгүй холбооны үйлчилгээ хүргэх	675.0	539.3
2	Хөдөө орон нутагт үүрэн холбооны үйлчилгээ хүргэх	235.3	235.3
3	Тоон технологид суурилсан радио өргөн нэвтрүүлгийг малчдад хүргэх	200.0	189.5
4	Орон нутагт харилцаа холбооны үйлчилгээний чанар, хамрах хүрээ, хүртээмжийг сайжруулах	310.0	0.0
5	Хөдөө орон нутгийн алслагдсан сум, суурин газарт болон суурин өргөн зурвасын сүлжээ байгуулах, интернэтийн үйлчилгээ хүргэх	240.0	192.0
6	Хөдөө орон нутагт дамжуулах интернэтийн чанар, хамрах хүрээг сайжруулах	1.200.0	1.199.9
7	Шуудангын салбарын үйлчилгээний хүргэлтийн давтамж, хүртээмжийг нэмэгдүүлэх, дэмжлэг үзүүлэх	300.0	298.8
8	Бүх аймаг, сумдын мэдээлэл холбооны сүлжээ, үйлчилгээний өнөөгийн түвшин, тоон ялгааг тодорхойлох судалгаа	49.7	39.8
9	Телевизийн олон сувгийн үйлчилгээний чанар, хамрах хүрээг сайжруулах, засвар үйлчилгээг шуурхай зохион байгуулах зорилгоор автомашин нийлүүлэх	50.0	40.0
10	Хөдөө орон нутгийн иргэдэд мэдээлэл харилцаа холбооны боловсрол олгох	240.0	--
	Нийт	3,500.0	2,734.6

2.2 Сангийн хөрөнгөөр санхүүжих 9 төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор 200.0 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй 7 арга хэмжээг ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг Худалдан авах ажиллагааны газар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, 50.0 сая төгрөгөөс доош үнийн дүн бүхий 2 төслийг МШХХТГ-аас ТБОНӨХБАУХА тухай хуулийн дагуу тус тус зохион байгуулсан байна.

Хөдөө орон нутгийн алслагдсан сум, суурин газарт утасгүй холбооны үйлчилгээ хүргэх төсөл

2.3 Энэхүү төслийг хэрэгжүүлэхээр “Жи-Мобайл” ХХК, “Мобиком” ХХК шалгарч баруун болон зүүн бүсийн аймгуудад утасгүй холбооны үйлчилгээг иргэдэд хүргэх ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

2.4 Баруун бүсийн алслагдсан цэгт үүрэн холбооны үйлчилгээ хүргэх төслийн хүрээнд Говь-Алтай аймгийн Дарви сум, Увс аймгийн Тэс, Хяргас сум, Завхан аймгийн

Нөмрөг сум, Баян-Өлгий аймгийн Булган суманд нийт 374,680.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий төслийг хэрэгжүүлэхээр “Жи-Мобайл” ХХК шалгарч гүйцэтгэжээ. Тус компани МШХХТГ-тай байгуулсан гэрээний дагуу ажлыг 2013 оны 9 дүгээр сарын 5-нд эхэлж мөн оны 10 дугаар сарын 20-ны өдөр ажлыг дуусгаж БНҮҮС-ийн Ажлын албанд хүлээлгэн өгсөн ба гэрээний тусгай нөхцлийн дагуу үйлчилгээг 6 сар тасралтгүй хүргэсний дараа үлдэгдэл 20 хувийн санхүүжилтыг олгоно гэж заасан байна.

Төслийн хүрээнд суурилуулсан тоног төхөөрөмжийн судалгаа, үнийн дүнг хүснэгтээр үзүүлбэл:

№	Тоног төхөөрөмжийн нэр	Техникийн тодорхойлолт	Тоо ширхэг	Нэгжийн үнэ
1	Бааз станц	SS BTS	1	10854.7
2	VSAT	D2,4	1	7153.6
3	Нарны контроллёр	100A	5	28719.5
4	Нарны толь кабель	195W	5	49284.0
5	Нарны тольны рак, дагалдах хэрэгсэл		4	33798.4
6	Батарей, кабель	2V 500 A/H	193	73915.3
7	Батарейны рак		5	1654.5
8	Батарейны дулаалга	Халдаг	1	896.1
9	Батарейны дулаалга	Энгийн	4	225.2
10	Бааз станц	MBTS 01	4	139462.4
11	Радио релей	D1,8	2	21178.0
12	Радио релей	D1,2	1	7538.0
13	Нийт үнэ			374679.7

2.5 Хөдөө орон нутгийн алслагдсан сум, суурин газарт утасгүй холбооны үйлчилгээ хүргэх төслөөр бий болсон тоног төхөөрөмж, эд хөрөнгийг БНҮҮС-ийн Ажлын алба байгууллагын санхүүгийн анхан шатны бүртгэлд бүртгэж аваагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1⁸ дэх заалтыг зөрчсөн байна.

2.6 Аудитын явцад 374.6 сая төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмж “Жи-Мобайл” ХХК өөрийн өмчид бүртгэсэн байна. Энэхүү харилцаа холбооны төхөөрөмжийг өөр үүрэн холбооны операторууд ашиглах боломжгүй юм байна.

Хөдөө орон нутагт үүрэн холбооны үйлчилгээ хүргэх төсөл

2.7 Төслийн хүрээнд Баянхонгор аймгийн нэр бүхий 3 суманд үүрэн холбооны сүлжээ хүргэх төсөлд шалгарсан “Жи-Мобайл” ХХК-д сангийн хөрөнгөөс нийт 235.3 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төслийн хэрэгжүүлэх зорилгоор суурилуулсан тоног төхөөрөмж, хөрөнгийн үнийн дүнг хүснэгтээр үзүүлбэл;

№	Тоног төхөөрөмжийн нэр	Техникийн тодорхойлолт	Тоо ширхэг	Нэгжийн үнэ Мян.төг
1	Бааз станц	MBTS 01	3	104,686.6
2	Радио релей	D1,2	1	10,589.0 /Аргалант/
3	Нарны контроллёр	100A,30A,60A	3	16,231.6
4	Нарны тольны рак, дагалдах хэрэгсэл		72	29,574.3
5	Батарей	2V 500 A/H	72	24,009.4

⁸ Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана.

6	VSAT	D2,4	2	14,307.3/Тамч,Мандал/
7	Байр	4м*4м	1	16,000.0 /Мандал/
8	Хашаа	10м*25м	1	6,701.9 /Аргалант/
9	Хашаа	20м*20м	2	12,200.0
Нийт				235,300.0

2.8 Хүснэгтэд дурьдсан нэр бүхий тоног төхөөрөмжийг БНҮҮС-ийн Ажлын алба хүлээж авахдаа байгууллагын эд хөрөнгийн бүртгэлд бүртгээгүй байна. Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1⁹ дэх заалтыг зөрчсөн байна.

2.9 Аудитын явцад 235.3 сая төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмж “Жи-Мобайл” ХХК-ийн өмчид бүртгэгдсэнийг тогтоосон ба БНҮҮС нь санхүүгийн тайлан балансад авлага, өглөгөөр бүртгээгүй байна.

2.10 Мөн хөдөө орон нутгийн сум суурин газарт, утасгүй холбооны үйлчилгээ хүргэх 299.5 сая төгрөгийн санхүүжилт бүхий төслийг Дорнод аймгийн Чойбалсан сум, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сум, Дорноговь аймгийн Сайхандулаан, Булган аймгийн Тэшиг сумдад хэрэгжүүлэхээр “Мобиком” ХХК шалгарсан ба гэрээний тусгай нөхцлийн дагуу үйлчилгээг 6 сар тасралтгүй хүргэсний дараа үлдэгдэл 20 хувийн санхүүжилтийг олгоно гэж заасан байна.

2.11 Тус компани гэрээнд заасны дагуу төслийн ажлыг 2013 оны 9 дүгээр сарын 5-нд эхэлж мөн оны 12 дугаар сарын 18-ны өдөр 238.9 сая төгрөгийн өртөг бүхий ажлыг хийж дуусган БНҮҮС-ийн Ажлын албанд хүлээлгэн өгсөн байна.

Төслийн хүрээнд дараах хөрөнгийг суурилуулж ашиглалтад оруулсан байна.

№	Булганы Тэшиг сум Залман уул	Төсөвт өртөг /мян.төг/
1	Бааз станц	37449.3
2	GSM Антенна	2445.8
3	Цамхаг, Станц бүтээн байгуулалт угсралтын зардал	46464.3
4	Висат антенна	23417.4
	Төвийн эрчим хүчний зардал	91570.0
	Сэргээгдэх эрчим хүчний зардал	37611.0
5	Нийт	238.9

2.12 Энэ төслийн хүрээнд Булган аймгийн Тэшиг сумын Залман ууланд хийгдэх 60.5 сая төгрөгийн өртөг бүхий ажил цаг агаарын нөхцөл байдлын улмаас хойшлогдон гэрээг 2014 оны 8 дугаар сарын 1-ний өдөр хүртэл сунган ажиллаж байна.

2.13 “Мобиком” ХХК-ийн гүйцэтгэсэн ажлыг гэрээнд заасны дагуу БНҮҮС-ийн Ажлын алба хүлээж авахдаа төслийн хүрээнд бий болсон нэр бүхий тоног төхөөрөмжийг байгууллагын эд хөрөнгийн бүртгэлд бүртгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалтыг зөрчсөн байна.

2.14 Аудитын явцад 89.5 сая төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмж “Мобиком” ХХК-ийн өмчид бүртгэгдсэнийг тогтоолоо.

⁹ Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана.

Орон нутагт харилцаа холбооны үйлчилгээний чанар, хамрах хүрээ, хүртээмжийг сайжруулах төсөл

2.15 Орон нутагт харилцаа холбооны үйлчилгээний чанар, хамрах хүрээ, хүртээмжийг сайжруулах 305.7 сая төгрөгийн өртөг бүхий төслийг хэрэгжүүлэхээр шалгарсан “Гуулин тал” ХХК-ийн ажлын гүйцэтгэлийг шалгахад МШХХТГ-тай байгуулсан гэрээнд заасан 2013 оны 12 дугаар сарын 15-ны хугацаанд хэрэгжиж дуусах боломжгүй байна.

2.16 Тус компани улирлын чанартай барилгын болон цамхаг усралтын ажлыг гүйцэтгэх байсан боловч гэрээг оройтож байгуулснаас хугацаандаа ажил дуусах боломжгүй болж, санхүүжилт хийгдээгүй байна. Гэрээний хугацааг 2014 оны 6 дугаар сарын 1-ний хүртэл МШХХТГ болон “Гуулин тал” ХХК харилцан тохиролцож дахин сунгасан боловч төслийн ажлын гүйцэтгэл хугацаандаа бүрэн хэрэгжиж дуусах боломжгүй байгааг аудитын явцад тогтоолоо.

Тоон технологид суурилсан радио өргөн нэвтрүүлгийг малчдад хүргэх төсөл

2.17 Тоон технологид суурилсан радио өргөн нэвтрүүлгийг малчдад хүргэх 199.5 сая төгрөгийн өртөг бүхий төслийн гүйцэтгэгчээр “Саруул асар” ХХК шалгарсан байна. Энэ компани хамгийн сүүлийн үеийн технологид үндэслэн хийгдсэн, аналог, тоон горимоор ээлжлэн ажиллах радио станц болох “DRM EXCITER” төхөөрөмжийг 2013 оны 10 дугаар сарын 7-ны өдөр Баян-Өлгий аймгийн “Радио телевизийн сүлжээ” УТҮГ-т суурилуулан хүлээлгэн өгсөн боловч одоогоор ашиглаж эхлээгүй байна.



2.18 Дээрх станц нь одоогоор аналог горимд шилжиж ажиллаагүй байгаа бөгөөд “DRM EXCITER” радио станцыг улсын хэмжээнд тоон технологид бүрэн шилжсэн үед ашиглах боломжтой байна.

“Хөдөө орон нутгийн алслагдсан сум, суурин газар, суурин өргөн зурвасын сүлжээ байгуулах, интернэтийн үйлчилгээ хүргэх” төсөл

2.19 БНҮҮС-аас хэрэгжүүлж буй “Хөдөө орон нутгийн алслагдсан сум суурин газарт утасгүй болон суурин өргөн зурвасын сүлжээ байгуулах, интернетийн үйлчилгээ хүргэх” ХААГ-АЭ-2013/8 дугаартай төслийг хэрэгжүүлэхээр шалгарсан “Ай Си Нэт” ХХК-тай МШХХТГ 2013 оны 12 дугаар сарын 13-ны өдөр гэрээ байгуулсан бөгөөд гэрээний тусгай нөхцөлд заасны дагуу 52 сум, 21 аймгийн төв болон алслагдсан дүүргүүдэд интернетийн үйлчилгээг үзүүлж байна.

Аудитын явцад 52 суманд үйлчилгээг хүргэж байгааг тогтоосон бөгөөд ажлын гүйцэтгэл нь 80 орчим хувийн гүйцэтгэлтэй ба өгсөн ба гэрээний тусгай нөхцлийн дагуу үйлчилгээг 6 сар тасралтгүй хүргэсний дараа үлдэгдэл 20 хувийн санхүүжилтыг олгоно гэж заасан байна.

Төслийг хэрэгжүүлэхэд дараах ажил хийгдсэн байна. Үүнд:

- Интернетийн үйлчилгээ үзүүлэгч нь захиалагчаас бэлтгэсэн сүлжээний дэд бүтцийг ашиглан Засаг даргын Тамгын газрыг 512 кбит/сек-ээс багагүй хурдаар интернет сүлжээнд холбосон.
- Сумын холбооны байрнаас эмнэлэг рүү татагдсан байгаа шилэн кабелийн холболт болон суурилагдсан свичийг ашиглан интернетийн үйлчилгээг хүргэсэн. Свич нь эмнэлэг дээр байрласан бөгөөд 10/100/1000 base-T Ethernet 24 порттой.
- Сумын төвийн иргэд утасгүй интернетийн үйлчилгээнд холбогдох боломжийг бий болгох зорилгоор тухайн интернетийн үйлчилгээ үзүүлэгч нь захиалагчаас бэлдсэн утасгүй интернетийн дэд бүтцийг ашиглан интернетийн үйлчилгээг үнэ төлбөргүй хүргэж байна.

Гэрээний хугацаанд дээрх 52 сум 21 аймгийн төв, алслагдсан дүүргүүдэд интернетийн үйлчилгээ үнэ төлбөргүй байна.

2.20 Мөн төслийн гүйцэтгэгч Баян-Өлгий тус аймгийн Сагсай, Алтай, Цагааннуур, Толбо, Дэлүүн, Ногооннуур сумдад интернетийн үйлчилгээг үзүүлэхээр шилэн кабель татаж шаардлагтай тоног төхөөрөмжийг суурилуулж аймгийн Мэдээлэл холбооны газрын сүлжээнд холбосон боловч одоогоор ашиглаагүй байна.

2.21 Дээрх сумдын шилэн кабель сурилуулалтын ажил бүрэн дуусч 2014 оны 6 дугаар сарын 1-ний өдөр техникийн комисс хүлээн авсан байна.

2.22 Төслийн хэрэгжилтийн үр дүнд бий болсон тоног төхөөрөмж, эд хөрөнгийн бүртгэлийг орон нутгийн байгууллагын санхүүгийн данс, бүртгэлд аваагүй байгааг аудитын явцад тогтоолоо.

“Хөдөө орон нутагт дамжуулах интернэтийн чанар, хамрах хүрээг сайжруулах” төсөл

2.23 БНҮҮС-аас хэрэгжүүлж буй ХААГ-АЭ-2013/5 дугаар төслийн гүйцэтгэгчээр “Мэдээлэл холбоо сүлжээ” ХК шалгарч 2013 оны 9 дүгээр сарын 5-ны өдөр МШХХТГ-тай гэрээ байгуулж гэрээний тусгай нөхцөлд заасны дагуу 21 аймгийн төв 227 суманд нийт 1,199.9 сая төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмжийг бүрэн суурилуулж, интернетийн үйлчилгээг үзүүлсэн байна.

2.24 Дээрх ажлын үр дүнд цахим үйлчилгээний хувьд хот хөдөөгийн ялгаа арилж, орон нутагт мэдлэгт тулгуурласан чиг баримжаа бүхий ажлын байрууд шинээр бий болох, түгжрэлгүй төрийн цахим үйлчилгээнүүдийг иргэд байршлаасаа үл хамааран цаг алдалгүй, түргэн шуурхай хүртэх боломж бүрдсэн байна.

“Шуудангын салбарын үйлчилгээний хүргэлтийн давтамж, хүртээмжийг нэмэгдүүлэх, дэмжлэг үзүүлэх” төсөл

2.25 БНҮҮС-аас хэрэгжүүлсэн 298.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ТН-ХААГ-АЭ-2013/4 дугаар бүхий төслийн гүйцэтгэгчээр “Монгол шуудан” ХК шалгарч МШХХТГ-тай гэрээ байгуулсан байна.

2.26 Энэ төсөл нь шуудангийн үйлчилгээг хүргэх, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, алслагдсан сумдад хүргэлтийн давтамжийг нэмэгдүүлж 7 хоногт 2-3 болгох, улмаар багийн шуудан хүргэлтийг 7 хоног тутам болгож нэмэгдүүлэх зорилготой байна.

2.27 Гэрээний тусгай нөхцөлд заасны дагуу Булган, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Орхон, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв зэрэг 9 аймгийн сум, багуудад шуудангийн үйлчилгээний хүргэлтийн давтамжийг нэмэгдүүлж үйлчилгээг тогтмол тасралтгүй болгосноор дээрх 9 аймгийн 115 суманд төслийг хэрэгжүүлэхээс өмнө

өөрийн болон гэрээт тээвэрлэгчээр 7 хоногт давхардсан тоогоор 222 удаа хүргэлт хийж байсан бол төслийг хэрэгжүүлснээр 298 удаа болж хүргэлтийн давтамжийг 34 хувиар нэмэгдүүлсэн байна.

2.28 Мөн сумын шуудан хүргэлтийн давтамжийг нэмэгдүүлснээр багийн шуудан хүргэлт сайжирч төсөл хэрэгжихээс өмнө дээрх 9 аймгийн 506 багийн 269 багт 7 хоногт 538 удаа хүргэлт хийж байсан бол төслийг хэрэгжүүлснээр 506 багт 7 хоногт 828 удаа хүргэлт хийдэг болж, улмаар хүргэлт хийгддэггүй байсан 237 багийг шинээр хүргэлтийн маршрутад хамруулсан байна.

“Бүх аймаг, сумдын мэдээлэл холбооны сүлжээ, үйлчилгээний өнөөгийн түвшин, тоон ялгааг тодорхойлох судалгаа” төсөл

2.29 БНҮҮС-аас хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр, харилцаа холбооны үйлчилгээ хэрэгцээ шаардлагыг тодорхойлох зорилго бүхий бүх аймаг, сумдын мэдээлэл холбооны сүлжээ, үйлчилгээний өнөөгийн түвшин, тоон ялгааг тодорхойлох 39.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй судалгаанд “Ди Би Си Өү Эн” ХХК шалгарч 2013 оны 10 дугаар сарын 25-ны өдөр МШХХТГ-тай гэрээ байгуулан ажиллаж 2013 оны 12 дугаар сарын 15-нд гүйцэтгэж дуусган тайланг БНҮҮС-ийн Ажлын албанд хүлээлгэж өгсөн байна.

“Телевизийн олон сувгийн үйлчилгээний чанар, хамрах хүрээг сайжруулах, засвар үйлчилгээг шуурхай зохион байгуулах зорилгоор автомашин нийлүүлэх” төсөл

2.30 Телевизийн олон сувгийн үйлчилгээний чанар, хамрах хүрээг сайжруулах, засвар үйлчилгээг шуурхай зохион байгуулах зорилгоор автомашин нийлүүлэхээр 50 сая төгрөгийн хөрөнгийг төлөвлөсөн ч гүйцэтгэлээр “Ниссан моторс” ХХК МШХХТГ-тай 2013 оны 8 дугаар сарын 27-нд гэрээ байгуулж 40.0 сая төгрөгийн үнэ бүхий Nissan Pick-up маркийн автомашиныг “Радио телевизийн сүлжээ” Улсын төсөвт үйлдвэрийн газарт 2013 оны 9 дүгээр сарын 2-нд хүлээлгэж өгсөн байна.

“Хөдөө орон нутгийн иргэдэд мэдээлэл харилцаа холбооны боловсрол олгох” төсөл

2.31 МШХХТГ-аас энэхүү төслийг хэрэгжүүлэх зорилгоор холбогдох тендерийн материалыг ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг “Худалдан авах ажиллагааны газар”-т хүргүүлснээр уг газар 2013 оны 10 дугаар сарын 10-ны өдөр Үнэлгээний хороо байгуулж мөн оны 11 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн “e-procurement” сайт болон сонин хэвлэлд тендерийн урилгыг нийтэлсэн байна. Дээрх төсөлд оролцох байгууллага, аж ахуйн нэгжээс үнийн санал ирүүлээгүй тул зөвлөх үйлчилгээний нээлттэй тендер шалгаруулалтыг 2014 оны 1 дүгээр сарын 2-нд хүчингүй болгосон байна.

2.32 Дээрх төслийг 2014 оны БНҮҮС-ийн хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн жагсаалтад оруулан 1 дүгээр сарын 23-нд Монгол Улсын Ерөнхий сайд баталсан байна.

БҮЛЭГ 3. БҮХ НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮҮРГИЙН САНГИЙН ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН ТАЛААР

Хяналтын зөвлөл БНҮҮС-ийн үйл ажиллагааны дүрмийг мөрдөж ажиллаагүй байна.

3.1 Сангийн орон тооны бус Хяналтын зөвлөл нь Мэдээлэл технологийн салбарын төрийн болон хувийн салбарын төлөөллөөс бүрдсэн 9 гишүүнийг 2 жилийн хугацаанд ажиллуулахаар МТШХХГ-ын дарга томилж, чөлөөлдөг байна.

3.2 Дээрх зөвлөл нь БНҮҮС-ийн үйл ажиллагаа хуулийн дагуу явагдаж байгаа эсэх, сангийн хөрөнгийн бүрдүүлэлт болон зарцуулалттай танилцаж санал, зөвлөмж өгөх, сангаас боловсруулсан төсөл хөтөлбөрийн төлөвлөгөөнд зөвлөмж гаргах эрх үүргийн хүрээнд ажиллахаар “БНҮҮС-ийн Үйл ажиллагааны дүрэм”-д тусгасан байна.

Хяналтын зөвлөлийн бүтэц бүрэлдэхүүнийг 2013 оны байдлаар хүснэгтээр үзүүлбэл:

Д/д	Хяналтын зөвлөлийн гишүүд	Нэрс
1	Радио телевизийн сүлжээний газрын дарга. Хяналтын зөвлөлийн дарга	Т.Гантөмөр
2	ШУТИС-ийн Мэдээллийн сүлжээний профессор ХЗ-ийн гишүүн	Н.Эрдэнэхүү
3	МЦХ ХК. Хөрөнгө оруулалт, худалдан авалтын хэлтсийн дарга. ХЗ-ийн гишүүн	Б.Сумъяажав
4	МХС ТӨК. Дотоод хяналт мониторингын газрын дарга. ХЗ-ийн гишүүн	Д.Моондой
5	Скайтел ХХК. Технологийн газрын захирал. ХЗ-ийн гишүүн	Ш.Батжаргал
6	Юнител ХХК-ийн Техникийн газрын захирал. ХЗ-ийн гишүүн	Д.Энхбат
7	Монгол Шуудан ХХК-ийн Дотоод хяналтын албаны дарга. ХЗ-ийн гишүүн	С.Шинэбаяр
8	Мобиком корпораци ХХК-ийн Стратеги төлөвлөлтийн албаны дарга. ХЗ-ийн гишүүн	Э.Шижир
9	Жи-Мобайл ХХК-ийн Сүлжээ төлөвлөлтийн хэлтэсийн дарга. ХЗ-ийн гишүүн	Г.Оюунбаяр

3.3 Дүрэмд заасны дагуу Хяналтын зөвлөл жилд нэгээс доошгүй хуралддаг бөгөөд энэхүү хурлаараа “Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн үйл ажиллагааны дүрэм”-ийн 5 дугаар зүйлийн 5.5.1-5.5.3¹⁰-т заасан үүргийг биелүүлэх талаар хангалтгүй ажилласан байна. Энэ нь Хяналтын зөвлөлийн хуралдааны тэмдэглэл, хурлаас гарсан зөвлөмж, шийдвэрээс тодорхой харагдаж байна.

3.4 МШХХТГ нь БНҮҮС-ийн хөрөнгийн бүрдүүлэлт зарцуулалтын тайланг жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан Засгийн газарт танилцуулдаг байна.

3.5 Сангийн санхүүгийн тайланг МШХХТГ Нэгдсэн төсвийн тухай хуульд заасан хугацаанд төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлдэг байна. БНҮҮС нь ашгийн бус байгууллага учраас орлогын албан татвараас бусад татварыг төсөвт төвлөрүүлэх үүрэг хүлээдэг ба 2013 онд нийгмийн даатгалын шимтгэлд нийт 5.2 сая төгрөгийг төлсөн байна.

¹⁰ 1. Сангийн үйл ажиллагаа хууль тогтоомж, дүрмийн дагуу явагдсан эсэх,
2. Сангийн хөрөнгийн бүрдүүлэлт болон зарцуулалттай танилцаж, санал зөвлөмж өгөх,
3. Тухайн жилд төлөвлөж баталсан арга хэмжээнүүдийн биелэлтийн үр дүнг нийтэд мэдээлэхэд оролцох

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт гаргаж байна. Үүнд:

1. Улсын хэмжээнд ХХЗХ-оос олгосон тусгай зөвшөөрөл бүхий 501 аж ахуйн нэгжээс 257 аж ахуйн нэгж хууль, журамд заасны дагуу БНҮҮС-ийн Ажлын албанд санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангаа ирүүлж байгаа нь тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжид тавих хяналт, шалгалт, хариуцлага тооцох асуудал хангалтгүй байгааг харуулж байна.
2. БНҮҮС-д төвлөрүүлэх нийт хөрөнгийн 80.5 хувь буюу 2.9 тэрбум төгрөгийг 71 аж ахуйн нэгж бүрдүүлсэн нь бусад 413 аж ахуйн нэгжээс авах татвар хураамжыг нөхөн төлүүлэх ажлыг БНҮҮС-ийн Ажлын алба зохион байгуулаагүй байна. Энэ нь БНҮҮС болон ХХЗХ хамтран ажилладаггүйтэй холбоотой байна.
3. Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн үр дүнд ашиглалтад орсон тоног төхөөрөмж, эд хөрөнгийг төрийн болон төрийн өмчийн оролцоотой байгууллагын санхүүгийн баримт бүртгэлд бүртгэж аваагүй байна.
4. Төслийг хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжүүд төслийн хөрөнгөөр бүрдсэн тоног төхөөрөмж, эд хөрөнгийг өөрийн аж ахуйн нэгжийн санхүүгийн дансанд бүртгэсэн байна.
5. Хяналтын зөвлөл нь “БНҮҮС-ийн үйл ажиллагааны журам”-д заасан үүргийг бүрэн биелүүлж ажиллаагүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурьдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Мэдээлэл технологи, шуудан харилцаа холбооны газрын дарга Ц.Жадамбаад:

1. ЗГ-ын 2009 оны 151 дүгээр тогтоолоор батлагдсан “БНҮҮС-г бүрдүүлэх зарцуулах журамд”-д сангийн бүрдүүлэлтийг бүрэн ханган биелүүлэхтэй холбоотойгоор БНҮҮС, ХХЗХ-ны хоорондын ажлын уяалдаа холбоог зохицуулах асуудал болон аж ахуйн нэгжүүдийн тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулж орлого олсон эсэхийг хэн яаж тогтоох тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хаягжилтыг улирал эсвэл сараар утсаар холбогдож хаягийг магадлан шалгаж байх гэх мэт эрхийн актад бүрхэг байгаа асуудлаар нэмэлт өөрчлөлт оруулах, хяналтын зөвлөлийг журмын дагуу ажиллуулах.
2. Төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгө, үзүүлсэн үйлчилгээг төрийн өмчид хэрхэн бүртгэх асуудлыг ТӨХ болон холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх.
3. Орон тооны бус Хяналтын зөвлөлийн үйл ажиллагааг журмын дагуу ажиллуулах.

Холбогдох байгууллагын санал



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

**МЭДЭЭЛЭЛ, ШУУДАН, ХАРИЛЦАА
ХОЛБОО, ТЕХНОЛОГИЙН ГАЗАР**

15160 Улаанбаатар хот,
Чингэлтэй дүүрэг, Сүхбаатарын талбай 1,
Утас: 33-07-90, 33-07-81, Факс: (976-11) 33-07-80,
E-mail: info@ictpa.gov.mn, http://www.ictpa.gov.mn

2014.06.20 № 1/035
танай 2014.06.11-ны № 842 -Т

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ДЭД ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БАТТУЯА ТАНАА**

Тус газрын “Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн үйл ажиллагаа, үр дүн”-д ирүүлсэн аудитын тайлангийн төсөлд өгөх саналыг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт... хуудас


ДАРГА

Ц.ЖАДАМБАА



112240

Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын даргын 2014 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн №... тоот албан тоотын хавсралт



БҮХ НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮҮРГИЙН САНГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАНД ӨГӨХ САНАЛ

Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 151 дүгээр тогтоолоор “Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан бүрдүүлэх, зарцуулах” журам батлагдсан цагаас өнөөг хүртэл тус сангийн хөрөнгө төвлөрүүлэлт, зарцуулалт, үйл ажиллагаанд Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар хяналт тавьж ажиллаж байна.

“МУ-ын 2013 оны төсвийн тухай” хуульд Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн орлогыг 3,5 тэрбум төгрөг, хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр арга хэмжээний зардлыг 3,5 тэрбум төгрөг, сангийн дотоод үйл ажиллагааны зардлыг 70 сая төгрөгөөр тус тус баталсан.

Сан нь төлөвлөгөөний дагуу 2,9 тэрбум төгрөгийг дансандаа төвлөрүүлж, 845,9 сая төгрөгийн авлагатай, хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр, арга хэмжээний зардалд 2,7 тэрбум төгрөг, дотоод үйл ажиллагааны зардалд 69 сая төгрөгийн гүйцэтгэлтэй ажилласан. Танай газраас ирүүлсэн “Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн үйл ажиллагаа, үр дүн”-д тайлангийн төсөлд дараах санал, тайлбарыг өгч байна.

САНАЛ 1. Сангийн хөрөнгө бүрдүүлэлтийн талаар

- 1.1. Засгийн газрын 2009 оны 151 дүгээр тогтоолоор батлагдсан “Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санг бүрдүүлэх, түүнийг зарцуулах журам”-д заасны дагуу 2013 оны 3 дугаар улирлын тооцоо нийлсэн байдлаар Харилцаа холбооны зохицуулах хорооноос 2013 онд лиценз эзэмшигч нийт 501 байгууллага байгаагаас 413 лиценз эзэмшигч байгууллагад утсаар болон албан бичгээр мэдээлэл хүргүүлэн ажилласанаас 257 тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагууд сантай тооцоо нийлж, 71 байгууллагын 2,9 тэрбум төгрөгийг дансанд төвлөрүүлж, 97 байгууллагын 845,9 сая төгрөгийн авлагатай ажилласан. /88 байгууллага хаяг тодорхойгүй, 156 байгууллага байгууллага тайлан ирүүлээгүй, 89 байгууллага хасах буюу ашиггүй тайлан ирүүлсэн/.
- 1.2. Төвлөрүүлбэл зохих 845 сая төгрөгийн авлага нь 2009-2013 оны 97 байгууллагын авлага бөгөөд хөрөнгө төвлөрүүлэхийг утсаар сануулах болон албан бичгээр удаа дараа шаардлага хүргүүлж ажилласанаас 2014.06.16-ны өдрийн байдлаар 6 байгууллагын 621 сая төгрөгийг төвлөрүүлсэн. /Хавсралтаар/
- 1.3. Сангийн хөрөнгийг төвлөрүүлэх талаар мэдээлэл хүргэх ажлын явцад тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хаяг байршил, холбоо барих утас байнга солигдож байдгаас үүдэн ихээхэн хүндрэлтэй байдаг. Үүнтэй холбоотойгоор мэдээллийн

санг үүсгэн өөрчлөгдсөн утас, хаяг байршлыг тухай бүрт нь тэмдэглэн ажиллаж байна.

1.4. Санд тайлангаа өгдөггүй хөрөнгө төвлөрүүлдэггүй зарим байгууллагын хувьд харилцаа холбооны лицензээс гадна бусад салбараас давхар лиценз эзэмшдэг нь харилцаа холбооноос олсон орлогоо худал мэдүүлж, нуун дарагдуулдаг. Олсон орлогыг салгаж тооцох талаар Татварын ерөнхий газраас зөвлөгөө авсан боловч орлогыг салгах боломжгүй тул бүрэн төвлөрүүлэхэд ихээхэн хүндрэл учирдаг. Харилцаа холбооны лиценз эзэмшигч байгууллагуудаас хөрөнгө төвлөрүүлэлтийг бүрэн төвлөрүүлэх тал дээр Харилцаа холбооны зохицуулах хороонд лиценз эзэмшигч байгууллагуудтай байгуулдаг гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах /БНҮҮС-нд хөрөнгө төвлөрүүлэх талаар тусгах/ санал, "Харилцаа холбооны тухай" хууль, "Засгийн газрын тусгай сангийн тухай" хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд холбогдох саналуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

САНАЛ 2. Төсөл хөтөлбөрийн талаар

2.1. Засгийн газрын 2012 оны 131 дүгээр тогтоолын дагуу Худалдан авах ажиллагааны газарт 7 төсөл, сангийн ажлын албанд 2 төсөл "Төрийн болон орон нутгийн өмчийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн дагуу зохион байгуулагдсан. Үүнээс 1 төсөл нь зөвлөх үйлчилгээний нээлттэй тендер шалгаруулалтаар зарлагдсан боловч ондоо багтаж гүйцэтгэгч шалгараагүй тул 2014 оны төсөвт тусгагдсан. Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн ажлын албанаас нийт 21 аймгийн /давхардсан тоогоор/ 241 сум, 3 багт үүрэн холбооны үйлчилгээ, интернэтийн үйлчилгээ, шуудангийн үйлчилгээ, радио телевизийн үйлчилгээ, судалгаа, сурталчилгаа зэрэг таван чиглэлээр үйлчилгээ хүргэн ажилласан. Нийт гэрээгээр 3,2 тэрбум, санхүүжилтаар 2,7 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй ажилласан. Дэлгэрэнгүй:

№	Төсөл хөтөлбөрийн нэр	Төлөвлөгөө	Гэрээ	Гүйцэтгэл	Гүйцэтгэгч	Тайлбар
1.1	Хөдөө орон нутагт үүрэн холбооны үйлчилгээ хүргэх	235.3	235.3	235.3	Жи мобайл ХХК	Бүрэн хэрэгжсэн.
1.2	Тоон технологид суурилсан радио өргөн нэвтрүүлгийг малчдад хүргэх	200.0	199.5	189.5	Саруул-Асар ХХК	Бүрэн хэрэгжсэн.
2.1	Хөдөө орон нутгийн алслагдсан сум, суурин газарт утасгүй холбооны үйлчилгээ хүргэх-Багц-1	675.0	374.6	299.7	Жи мобайл ХХК	Утасгүй холбооны үйлчилгээг хүргэх бэлтгэл ажил бүрэн хийгдсэн. Гэрээний тусгай нөхцлийн дагуу үйлчилгээг 6 сар тасралтгүй хүргэсний дараа үлдэгдэл 20 хувийн санхүүжилтийг олгоно.
2.2	Хөдөө орон нутгийн алслагдсан сум, суурин газарт утасгүй холбооны үйлчилгээ хүргэх-Багц-2		299.5	239.6	Мобиком корпораци ХХК	
3	Орон нутагт харилцаа холбооны үйлчилгээний чанар, хамрах хүрээ, хүртээмжийг сайжруулах	310.0	305.7	-	Гуулин тал ХХК	Улирлын чанартай ажил тул 10 сард тухайн орон нутгууд нь хүйтний улирал эхэлсэнтэй холбогдуулан

						зөвшөөрөл олгоогүй тул 2014.06.01 хүртэл гэрээний хугацааг сунгасан. Улсын комисс хүлээж авахаар ажиллаж байна.
4	Хөдөө орон нутгийн алслагдсан сум, суурин газарт утасгүй болон суурин өргөн зурвасын сүлжээ байгуулах, интернэтийн үйлчилгээ хүргэх	240.0	240.0	192.0	Ай Си Нэт ХХК	Интернэтийн үйлчилгээг хүргэх бэлтгэл ажил бүрэн хийгдсэн. Гэрээний тусгай нөхцлийн дагуу үйлчилгээг 6 сар тасралтгүй хүргэсний дараа үлдэгдэл 20 хувийн санхүүжилтийг олгоно.
5	Хөдөө орон нутагт дамжуулах интернэтийн чанар, хамрах хүрээг сайжруулах	1,200.0	1,199.9	1,199.9	МХС ХХК	Бүрэн хэрэгжсэн.
6	Шуудангийн салбарын үйлчилгээний хүргэлтийн давтамж, хүртээмжийг нэмэгдүүлэх, дэмжлэг үзүүлэх	300.0	298.8	298.8	Монгол шуудан ХХК	Бүрэн хэрэгжсэн.
7	Телевизийн олон сувгийн үйлчилгээний чанар, хамрах хүрээг сайжруулах, засвар үйлчилгээг шуурхай зохион байгуулах зорилгоор автомашин нийлүүлэх	50.0	40.0	40.0	Ниссан моторс ХХК	Бүрэн хэрэгжсэн.
8	Бүх аймаг, сумдын мэдээлэл холбооны сүлжээ, үйлчилгээний өнөөгийн түвшин, тоон ялгааг тодорхойлох судалгаа	49.7	39.8	39.8	Ди Би Си Өү Эн ХХК	Бүрэн хэрэгжсэн.
9	Хөдөө орон нутгийн иргэдэд мэдээлэл харилцаа холбооны боловсрол олгох төсөл	240.0	-	-	-	2013.11.01-ны өдөр ХААГ-дээр зөвлөх үйлчилгээний нээлттэй тендер шалгаруулалтаар зарлагдсан боловч ондоо багтаж гүйцэтгэгч шалгараагүй тул 2014 оны төсөвт тусгагдсан.
Нийт		3 500.0	3 233.1	2 734.8		

2.2. Төсөл хөтөлбөрийн хэрэгжилт

Мобиком корпораци ХХК

“Хөдөө орон нутагт үүрэн холбооны үйлчилгээ хүргэх” Багц-2 “Зүүн бүсийн алслагдсан цэгт үүрэн холбооны үйлчилгээ хүргэх” ХААГ-АЭ-2013/7 төслийн гүйцэтгэгчээр Мобиком корпораци ХХК ажиллаж байгаа бөгөөд тухайн үед цаг уурын хүндрэлтэй нөхцөл байдал үүссэний улмаас Гэрээний 2.5.3 заалтыг 2013

оны 12-р сарын өдөр харилцан тохиролцсоны үндсэн дээр дэд бүтцийн түр сүлжээг 2013 оны 12-р сарын 20-ны байдлаар Гэрээний Хавсралт №3-аар байгуулан үйлчилгээг хүргэн ажилласан.

Булган аймгийн Тэшиг сумын Залман ууланд хийгдэх үндсэн байгууламжийг байгуулах ажлыг гүйцэтгэхэд Сайтын газрын зөвшөөрлийг 2014 оны 5-р сарын 01-нээс олгож эхэлсэн, цахилгаан тэжээлийн техникийн нөхцөлийг 2014 оны 3-р сарын 15-наас олгож эхэлсэн, хаврын хуурайшилтын үеийг харгалзан ой хээрийн гал түймрээс сэргийлэх зорилгоор хээрийн ажлын зөвшөөрөл олгогдоогүй ба сүлжээ байгуулах цэг нь уулын өндөрлөг хэсэгт байрлаж байгаагаас шалтгаалан өвлийн улиралд уг сайт руу очих боломжгүй гэж үзээд inoog сайт байгуулах шаардлага тулгарсан. Залман уул нь эгц өндөр /бартаа хад асга ихтэй/ 1853 метрт байрлах тул цас бүрэн хайлаагүй уулын үертэй байгаа нөхцөлд тоног төхөөрөмж тээвэрлэн хүргэх боломжгүй нөхцөл үүсч хугацаат ажлыг гүйцэтгэхэд хүндрэл үүссэн тул гэрээний хугацааг 2014 оны 8-р сарын 1-ний өдөр хүртэл сунгаж хяналт тавин ажиллаж байна.

Гуулин тал ХХК

“Орон нутагт харилцаа холбооны үйлчилгээний чанар, хамрах хүрээ, хүртээмжийг сайжруулах” ХААГ-АЭ-2013/6 төслийн гүйцэтгэгчээр Гуулин тал ХХК ажиллаж байгаа бөгөөд ажил эхлүүлэхэд шаардлагатай орон нутгийн зөвшөөрлүүд хүйтэрсэнтэй холбоотойгоор 2013 оны 10 сард олгогдоогүйн улмаас нөхцөл байдлыг харгалзан үзэж сунгасан ба Говь-Алтай аймгийн төв дээр 25м-н өндөртэй ТВ цамхаг байгуулж, аймгийн Радио Телевизийн Сүлжээ УТҮГазарт 2013 оны 03-р сарын 24-нд хүлээлгэж, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутагт 15м цамхаг, тоон радио релей, 4*6м2 техникийн байр, нарны зайн төхөөрөмж суурилуулах зэрэг ажлуудыг хийж, Сүхбаатар аймгийн Дарьганга сумын нэг цэгийн үйлчилгээний ажил бүрэн хийгдэж техникийн комисст хүлээлгэж өгөхөөр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Ай си нэт ХХК

“Хөдөө орон нутгийн алслагдсан сум, суурин газарт утасгүй болон суурин өргөн зурвасын сүлжээ байгуулах, интернэтийн үйлчилгээ хүргэх” төслийн гүйцэтгэгчээр Ай си нэт ХХК ажиллаж байгаа бөгөөд Төслийн хүрээнд нийт 21 аймгийн төв, 52 сум, 3 алслагдсан дүүрэгт байгуулсан түгээх сүлжээний дэд бүтцийг ашиглан эмнэлэг, Засаг даргын Тамгын газарт интернэтийн үйлчилгээ хүргэх, утасгүй сүлжээний дэд бүтцийг ашиглан иргэд, олон нийтэд интернетийн үйлчилгээг үнэ төлбөргүй ашиглах боломжийг бүрдүүлэх, интернэтийн үйлчилгээний төвийн үйлчилгээг хүргэн бүх нийтийн үүрэг хүлээн ажиллаж байна.

Тус төслөөс үлдсэн Баян-Өлгий аймгийн Сагсай, Цагааннуур, Толбо, Алтай, Дэлүүн, Ногооннуур сумдын шилэн кабель суурилуулалтын ажил бүрэн дуусч 2014.06.01-ны өдөр техникийн комисс хүлээн авсан ба Монгол Улсын Засгийн

Газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх томоохон зорилтуудын нэг болох “Хөдөө орон нутагт өндөр хурдны өргөн зурвасын сүлжээ байгуулах” үндэсний хөтөлбөрийн хүрээнд шилэн кабельд шинээр холбогдсон 150 сумдад нээлтийн үйл ажиллагаа хийхтэй холбогдуулан дээрх сумдад 2014 оны 6 дугаар сарын 19-ний өдөр интернэтийн үйлчилгээг эхлүүлэн үйлчилгээг хүргэхээр төлөвлөн ажиллаж байна.

2.3. Төсөл хөтөлбөрийн өмч хөрөнгө

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр, арга хэмжээнүүд нь үүрэн холбооны үйлчилгээ, интернэтийн үйлчилгээ, шуудангийн үйлчилгээ, радио телевизийн үйлчилгээ, судалгаа, сурталчилгаа зэрэг нэр төрлийн хүрээнд хөрөнгө бэлтгэх, ажил үйлчилгээ үзүүлэх гэсэн 2 үндсэн хэсэгт хуваагдаж байгаа бөгөөд дуусаагүй үйлдвэрлэлийн дансанд төслүүдийг бүртгэсэн бөгөөд 30 хувь нь хөрөнгө бэлтгэх, 70 хувь нь ажил үйлчилгээ үзүүлэх төслүүд байна. Үүнд:

- “Телевизийн олон сувгийн үйлчилгээний чанар, хамрах хүрээг сайжруулах, засвар үйлчилгээг шуурхай зохион байгуулах зорилгоор автомашин нийлүүлэх”/Ниссан моторс ХХК/, Тоон технологид суурилсан радио өргөн нэвтрүүлгийг малчдад хүргэх”/Саруул асар ХХК/ төслүүд бүрэн хэрэгжиж хөрөнгө бэлтгэсэн 2 төслийг Төрийн өмчийн хороонд бүртгүүлэхээр ажилласан.
- “Хөдөө орон нутагт үүрэн холбооны үйлчилгээ хүргэх”/Жи-мобайл/, “Хөдөө орон нутагт дамжуулах интернэтийн чанар, хамрах хүрээг сайжруулах”/МХС ТӨК/, “Шуудангийн салбарын үйлчилгээний хүргэлтийн давтамж, хүртээмжийг нэмэгдүүлэх, дэмжлэг үзүүлэх”/Монгол шуудан ТӨХК/, “Бүх аймаг, сумдын мэдээлэл холбооны сүлжээ, үйлчилгээний өнөөгийн түвшин, тоон ялгааг тодорхойлох судалгаа”/Ди Би Си Өү Эн ХХК/ төслүүд бүрэн хэрэгжиж ажил үйлчилгээ үзүүлсэн 4 төслийг зохих эрхийн актыг үндэслэн Төрийн өмчийн хороогоор шийдүүлэхээр ажиллаж байна.
- “Орон нутагт харилцаа холбооны үйлчилгээний чанар, хамрах хүрээ, хүртээмжийг сайжруулах”/Гуулин тал ХХК/, “Хөдөө орон нутагт үүрэн холбооны үйлчилгээ хүргэх”/Мобиком ХХК/, “Хөдөө орон нутгийн алслагдсан сум, суурин газарт утасгүй болон суурин өргөн зурвасын сүлжээ байгуулах, интернэтийн үйлчилгээ хүргэх”/Ай си нэт ХХК/ төслүүд нь хэрэгжих дуусаагүй байгаа тул хөрөнгийн асуудлыг төсөл бүрэн хэрэгжиж дууссаны дараа шийдэгдэнэ.

САНАЛ 3. Хяналтын зөвлөлийн талаар

Засгийн газрын 151 дүгээр тогтоолын 2.3-д “Мэдээллийн технологи, цахилгаан холбоо, шуудан болон радио телевизийн чиглэлээр үйлчилгээ

эрхлэгчдийн төлөөллөөс бүрдсэн орон тооны бус Хяналтын зөвлөл сангийн үйл ажиллагаанд хяналт тавина” мөн МТШХХГ-ын даргын 2013 оны 107 дугаар тушаалаар батлагдсан “Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн үйл ажиллагааны дүрэм”-ийн 5.1-д “Радио телевизийн тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн төлөөллөөс 1, Шуудангийн тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн төлөөллөөс 1, Мэдээллийн технологийн мэргэжилтэн бэлтгэдэг их дээд сургуулийн төлөөллөөс 1, Мэдээлэл, харилцаа холбооны салбарын төлөөллөөс 6 нийт 9 хүний бүрэлдэхүүнтэй” гэж баталсан бөгөөд 5.2-д “Сонгогдон ажиллах хугацаа нь 2 жил”, 5.5-д “Сангийн үйл ажиллагаа хууль тогтоомжийн дагуу явагдсан эсэх, сангийн хөрөнгийн бүрдүүлэлт болон зарцуулалттай танилцаж, санал зөвлөмж өгөх, тухайн жилд төлөвлөж баталсан арга хэмжээнүүдийн биелэлтийн үр дүнг олон нийтэд мэдээлэхэд оролцох” эрх үүрэгтэйгээр ажиллаж гэж заасан байдаг ба Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн орон тооны хяналтын зөвлөлийн дарга болон гишүүдийг холбогдох газруудаас санал авч МТШХХГ-ын даргын 2013 оны 109 дүгээр тушаалаар баталсан .

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн ажлын албанаас 2014 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр Хяналтын зөвлөлийн гишүүдэд 2013 онд хэрэгжүүлсэн дотоод үйл ажиллагаа, хөрөнгө бүрдүүлэлт, хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр, арга хэмжээний тайлан, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, төсвийн асуудал эрхэлсэн төв байгууллагад хүргүүлсэн тайлангуудыг тус тус танилцуулсан ба дүрмийн дагуу Хяналтын зөвлөлийн дарга нь “Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн үйл ажиллагааны дүрэм”-д заасан эрх үүргийнхээ дагуу хяналтын зөвлөлийн гишүүдийн санал, зөвлөмжийг нэгтгэж сангийн ерөнхий менежер болон сангийн менежерт өгч ажилласан.

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн ажлын алба нь дотоод үйл ажиллагаа, хөрөнгө бүрдүүлэлт, зарцуулалтыг тайланг Хяналтын зөвлөлд тайлагнахаас гадна Монгол Улсын Нэгдсэн төсвийн тухай хуульд заасан хугацаанд Төсвийн асуудал эрхэлсэн төв байгууллагад хуульд заасан хугацаанд үйл ажиллагаа, хөрөнгө бүрдүүлэлт, хөрөнгийн зарцуулалтыг тогтмол хүргүүлэн ажилладаг.

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн орон тооны бус хяналтын зөвлөл, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, төсвийн асуудал эрхэлсэн төв байгууллагын хуралдааны тэмдэглэл, хурлаас гарсан шийдвэр, санал, зөвлөмжийн биелэлтийг тухай бүрт нь Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн ажлын албаны дотоод үйл ажиллагаанд тусган ажиллаж байна.

БҮХ НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮҮРГИЙН САН

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн тайлангийн төсөлд МШХХТГ-аас ирүүлсэн саналд өгсөн тайлбар:

1. Хөдөө орон нутгийн алслагдсан сум, суурин газарт утасгүй холбооны үйлчилгээ хүргэх, Хөдөө орон нутгийн алслагдсан сум, суурин газарт болон суурин өргөн зурвасын сүлжээ байгуулах, интернэтийн үйлчилгээ хүргэх төсөл хөтөлбөрийн санхүүжилтийг гэрээний тусгай нөхцөлийн дагуу үйлчилгээг 6 сар тасралтгүй хүргэсний дараа үлдэгдэл 20 хувийн санхүүжилтийг олгоно гэсэн саналыг хүлээн авч тайланд тусгав.

2. Хөдөө орон нутгийн алслагдсан сум, суурин газарт утасгүй холбооны үйлчилгээ хүргэх төслийн хүрээнд Булган аймгийн Тэшиг сумын Залман ууланд хийгдэх 60.5 сая төгрөгийн өртөг бүхий ажил цаг агаарын нөхцөл байдлын улмаас хойшлогдон гүйцэтгэгч “Мобиком” ХХК-тай гэрээг 2014 оны 8 дугаар сарын 1-ний өдөр хүртэл сунгасан саналыг тайланд тусгав.

3. Хөдөө орон нутгийн алслагдсан сум, суурин газарт утасгүй болон суурин өргөн зурвасын сүлжээ байгуулах, интернетийн үйлчилгээ хүргэх төслийг хэрэгжүүлэгч “Ай си нэт” ХХК-ийн хэрэгжүүлсэн төслөөс үлдсэн Баян-Өлгий аймгийн Сагсай, Цагааннуур, Толбо, Алтай, Дэлүүн, Ногооннуур сумдын шилэн кабель суурилуулалтын ажил бүрэн дуусч 2014 оны 6 дугаар сарын 1-ний өдөр техникийн комисс хүлээн авсан гэх саналыг хүлээн авч тайланд тусгалаа.



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2014 оны 10 сарын 14 өдөр

Дугаар 286

Улаанбаатар хот

Нийцлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

"Төрийн аудитын тухай хууль"-ийн 13 дугаар зүйлийн 13.4.5, "Гүйцэтгэлийн шалгалтын журам"-ын 23.2, "Гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулах журам"-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүнд хийсэн нийцлийн аудитын тайланг баталсугай.
2. Аудитын явцад илэрсэн зөрчлийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг УИХ-ын Төсвийн байнгын хороо, Монгол Улсын Ерөнхий сайдад хүргүүлсүгэй.
4. Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хамжээ авч, үр дүнг 2015 оны 1 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Сангийн сайд, Хууль зүйн сайд, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд, Хөдөлмөрийн сайд, Эрүүл мэндийн сайд, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга, Мэдээлэл технологи, шуудан харилцаа холбооны газрын дарга нарт зөвлөсүгэй.
5. Аудитын зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Нийцлийн аудитын газрын дарга /Б.Алтанзул/-д даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД